



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ "МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

БОДЛОГЫН ӨРТӨГ ТООЦОХ АРГА ЗҮЙН УДИРДАМЖИЙГ СОНГОСОН ХӨТӨЛБӨРТ ТУРШСАН ҮР ДҮН

Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг
дэмжих зээлийн хөтөлбөрийн үнэлгээ

УЛААНБААТАР
2024





Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



БОДЛОГЫН ӨРТӨГ ТООЦОХ АРГА ЗҮЙН УДИРДАМЖИЙГ СОНГОСОН ХӨТӨЛБӨРТ ТУРШСАН ҮР ДҮН



Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг
дэмжих зээлийн хөтөлбөрийн үнэлгээ

УЛААНБААТАР
2024

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

БОДЛОГЫН ӨРТӨГ ТООЦОХ АРГА ЗҮЙН УДИРДАМЖИЙГ СОНГОСОН ХӨТӨЛБӨРТ ТУРШСАН ҮР ДҮН

Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хөтөлбөрийн үнэлгээ

Боловсруулсан:

Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн зөвлөх баг

Энэхүү “Бодлогын өртөг тооцох арга зүйн удирдамжийг сонгосон хөтөлбөрт туршсан үр дүн” Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хөтөлбөрийн үнэлгээний тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ГАРЧИГ

Оршил	4
1. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн танилцуулга	5
2. Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн түүвэр судалгааны үр дүн	7
2.1. Түүврийн аргачлал	7
2.2. Түүвэр судалгааны үр дүн	8
3. Зээлийн хөтөлбөрийн өртөг тооцох аргачлал	18
3.1. Хөтөлбөрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн суваг	18
3.2. Хөтөлбөрийн зээлийн нийт эдийн засгийн нөлөөг тооцоход ашиглаж байгаа загварын тухай	19
4. Хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлийн нөлөө	21
4.1. Төсөвт үзүүлэх шууд нөлөө	21
4.2. Эдийн засгийн шууд (статик) нөлөө	22
4.3. Эдийн засгийн нийт нөлөө	23
5. Дүгнэлт	27

ОРШИЛ

Улсын Их Хурлын Тамгын Газар, Эдийн Засгийн Хөгжлийн Яамны захиалгаар, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй “Бодлогын өртөг тооцох арга зүйн удирдамжийг сонгосон хөтөлбөрт туршсан үр дүн” зөвлөх үйлчилгээний хүрээнд энэ тайланг бэлтгэлээ. Зөвлөх үйлчилгээний үндсэн тайланд бодлогын өртөг тооцох олон улсын туршлагад үндэслэсэн аргачлалыг боловсруулж танилцуулсан. Харин энэ тайланд дээрх аргачлалыг ашиглан, сонгосон нэг бодлогын өртгийг тооцсон жишээг танилцуулав.

Тухайлбал, судалгааны энэ хэсэгт бид УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын бодлогын өртгийг үнэлэхийг зорьсон. Иймээс энэ тогтоолын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны хэрэгжүүлж буй Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээний талаарх мэдээллийг цуглуулж, бодлогын өртөг тооцох суурь загвараар нэмэлт тооцоог гүйцэтгэв. 2023 онд арга хэмжээний хүрээнд олгосон зээлийн мэдээллийг ХХААХҮЯ-аас авсан бол зээлд хамрагдсан аж ахуйн нэгж (ААН)-үүдийн түүвэр судалгаагаар тэдний бизнесийн үйл ажиллагаа, зээлийн зарцуулалттай холбоотой мэдээллийг нэмж цуглуулсан. Эдгээр цуглуулсан мэдээллээс зарим шаардлагатай үзүүлэлтүүдийг тооцож, бодлогын өртөг тооцох загварт ашиглав.

Энэхүү тайлан дараах бүтэцтэй. Тайлангийн 1-р бүлэгт энэхүү хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн талаар, 2-р бүлэгт уг зээлд хамрагдсан ААН-үүдийн түүвэр судалгааны үр дүнг танилцуулна. 3-р бүлэгт уг хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн үр нөлөөг тооцох буюу бодлогын өртөг тооцох аргачлалыг тайлбарлав. 4-р бүлэгт энэхүү хөтөлбөрийн үнэлгээний үр дүнг танилцуулав. Эцэст нь энэхүү хөтөлбөрийн үнэлгээг дүгнэсэн.

1

**ХҮНСНИЙ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ ЗЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 6-р сард Монгол Улсын Их Хурал (УИХ) “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд 2023 оны УИХ-ын түр хорооны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газар (ЗГ)-ын 2023 оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолоор арилжааны банкны эх үүсвэрээр хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн.

Уг зээлд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эргэлтийн хөрөнгөөр дэмжих хүрээнд жилийн 18 хувь (зээлдэгчээс 5 хувь, ЗГ хариуцан төлөх 13 хувь)-ийн хүүтэй, 36 хүртэл сарын хугацаатай зээл, хөрөнгө оруулалтыг дэмжих хүрээнд жилийн 19 хувь (зээлдэгчээс 6 хувь, ЗГ хариуцан төлөх 13 хувь)-ийн хүүтэй, 60 хүртэл сарын хугацаатай зээл багтана. УИХ-ын 36-р тогтоолд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх дараах таван чиглэлээр арга хэмжээ авахыг ЗГ-т даалгасан байна. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах,
- Удирдлага, зохион байгуулалт,
- Газар тариалангийн үйлдвэрлэл,
- Мал аж ахуйн үйлдвэрлэл,
- Хүнсний боловсруулах үйлдвэрлэл.

Бидний үнэлэх хөтөлбөрийн зээл дээрх таван чиглэлийн сүүлийн гурван чиглэлд ерөнхийдөө хамаарах бөгөөд нарийвчилбал, УИХ-ын 36 дугаар тогтоолын Хавсралтын 3.1.3, 3.2.3, 3.4.1, 3.5.2, 3.8.1, 4.1.1.2, 4.3.2, 4.3.2.1, 4.3.3, 4.4.1.1, 4.5.2, 5.2, 5.4.2, 5.5.3, 5.6.3, 5.6.4, 5.7.3 хэсгүүдтэй тус тус шууд холбогдоно. Хөтөлбөрийн зээлийг 2023 оны 4-р сараас арилжааны есөн банкны эх үүсвэрээр олгож эхэлжээ. Хүснэгт 1-д хүнс, газар тариалан, мал аж ахуй гэсэн гурван үндсэн салбараар олгосон зээлийн хэмжээ, зээлдэгчийн тоог харууллаа.

Нийт батлагдсан зээл 982 тэрбум төгрөгөөс 2023 оны 4-р сараас эхлэн 12-р сарыг дуустал 832.7 тэрбум төгрөгийн зээлийг нийт 1956 зээлдэгчид (1067 аж ахуйн нэгж байгууллага, 889 иргэн) олгосон бол хүнсний салбарт 592.1 тэрбум төгрөгийг (71.1 хувь) 499 зээлдэгчид, газар тариалангийн салбарт 186.5 тэрбум төгрөгийг (22.4 хувь) 1317 зээлдэгчид, мал аж ахуйн салбарт 54.2 тэрбум төгрөгийг (6.5 хувь) 140 зээлдэгчид тус тус олгожээ.

Хүснэгт 1. Хөтөлбөрийн олгосон зээл*, зээлдэгчийн тоо (салбар, сараар)

Он, сар	Хүнсний үйлдвэрлэл		Газар тариалан		Мал аж ахуй		Олгосон зээл	Зээлдэгчийн тоо	Дундаж зээлийн хэмжээ
	Зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо			
2023/04	4,475.4	20	14,963.3	208	70.0	1	19,509	229	85
2023/05	64,060.4	126	69,007.1	698	4,082.0	25	137,150	849	162
2023/06	122,759.6	127	36,665.2	260	22,112.0	48	181,537	435	417
2023/07	96,087.7	59	14,684.5	49	13,265.0	22	124,037	130	954
2023/08	19,714.6	35	5,559.3	33	5,395.0	19	30,669	87	353
2023/09	44,718.5	36	3,490.9	23	663.5	8	48,873	67	729
2023/10	35,537.0	22	2,043.1	12	2,031.4	5	39,611	39	1,016
2023/11	73,011.0	23	13,476.4	12	727.0	3	87,214	38	2,295
2023/12	131,691.9	51	26,592.9	22	5,850.0	9	164,135	82	2,002
Нийт	592,056	499	186,483	1,317	54,196	140	832,735	1,956	426

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

Тэмдэглээ: *-сая төгрөгөөр

Нийт олгогдсон зээлээс хөрөнгө оруулалтын зээлд 421.7 тэрбум төгрөгийг 366 зээлдэгчид, эргэлтийн хөрөнгийн зээлд 411 тэрбум төгрөгийг 1590 зээлдэгчид олгосон байна. Нэг зээлдэгчид олгосон хамгийн өндөр дүнтэй зээл 20 тэрбум төгрөг байсан бол хамгийн бага дүнтэй зээл 1.2 сая төгрөг байв. 5, 6, 7, 12-р сард хөтөлбөрийн зээл (харгалзан 137.2 тэрбум төгрөг, 181.5 тэрбум төгрөг, 124 тэрбум төгрөг, 164.1 тэрбум төгрөг) хамгийн идэвхтэй олгогдсон бөгөөд нийт олгогдсон зээлийн 72.9 хувьтай тэнцүү гэсэн үг.

2 ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

УИХ-ын 2022 оны 6-р сарын “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-р тогтоолын хүрээнд хүнс, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 2023 онд хамрагдсан ААН-үүдээс түүвэр судалгаа авсан. Энэ судалгаа нь судалгааны багийн боловсруулсан өртөг тооцох макро-төсвийн загварт шаардагдах нэмэлт мэдээллийг бүрдүүлэх үндсэн зорилготой.

Түүвэр судалгаагаар хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг нь хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа болон уг арга хэмжээ эдийн засгийн бусад салбарт ямар шууд нөлөө үзүүлэх боломжтойг тодруулав. Ингэхдээ хөнгөлөлттэй зээлийн төрөл болох хөрөнгө оруулалтын зээл, эргэлтийн хөрөнгийн зээлийн ялгааг тодорхойлох, хүнс, газар тариалан, мал аж ахуйн дэд салбарууд дахь дэмжлэгийн ижил болон ялгаатай нөлөөг харьцуулав.

2.1. Түүврийн аргачлал

Түүвэр судалгааны мэдээллийг дараах аргачлалаар цуглуулсан. Үүнд:

- Энэ судалгаанд зорилтот түүврийн (purposeful sampling) аргыг хэрэглэв. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанаас хамаарч хөнгөлөлттэй зээлийн хэмжээ янз бүр олгогдсон бөгөөд хамгийн их зээл авсан аж нэгжүүдийг сонгож мэдээлэл цуглуулах нь улсын төсөв болон нийт эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэхэд тохиромжтой юм.
- Түүврийн хэмжээ 110 аж ахуйн нэгж байхаар төлөвлөсөн. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 1956 иргэд, аж ахуйн нэгжээс ХХААХҮЯ хамгийн их зээл авсан 220 аж ахуйн нэгжтэй хяналтын гэрээ байгуулсан байна. Уг гэрээ байгуулсан ААН-үүд нь хөтөлбөрийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Иймээс судалгааны баг эдгээр хяналтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн 50% буюу 110 аж ахуйн нэгжээс мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн.
- Түүвэрт дэд салбарын төлөөллийг харгалзан үзсэн. Хяналтын гэрээтэй аж ахуйн нэгжүүдийн дэд салбарын хамрагдалтаас хамаарч хүнсний дэд салбараас 80, газар тариалангийн дэд салбараас 15 сав баглаа боодлын дэд салбараас 10, мал аж ахуйн дэд салбараас 5 аж ахуйн нэгжийг сонгосон.
- Түүвэр судалгаанд утсаар болон нүүр тулсан ярилцлагын аргыг хослуулан хэрэглэв. Судалгааны баг ХХААХҮЯ-ны мэргэжилтнүүдээс хяналтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн холбоо барих утасны дугаарын жагсаалтыг авсан. Аж ахуйн

нэгжүүдтэй энэ утсаар холбогдон зөвшөөрөл авч, утсаар болон биечлэн ярилцах аль тохиромжтой хэлбэрээр мэдээлэл цуглуулав. Аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоох, мэдээлэл цуглуулахад ХХААХҮЯ-ны хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд хамтран ажилласан.

- Хугацаа хэмнэх үүднээс хяналтын гэрээнд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн бүртгэл дээрх мэдээллийг ХХААХҮЯ-ны мэргэжилтнүүдээс шууд авч ашигласан. Үүнд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн төрөл, хэмжээ, байршил, үйл ажиллагааны чиглэл, суурь үеийн үйлдвэрлэл, борлуулалт, ажиллах хүчний хэмжээ гэх мэт.
- Түүвэр судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулсан. Түүвэр судалгааны мэдээллийг урьдчилан бэлтгэсэн, бүтэцлэгдсэн асуулгын маягтаар цуглуулав. Асуулга нь ААН-ийн үндсэн мэдээлэл, бизнесийн үйл ажиллагааны мэдээлэл, зээлийн мэдээлэл гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Асуулгын маягыг судалгааны баг болон ХХААХҮЯ-ны мэргэжилтнүүд хамтран боловсруулсан.

2.2. Түүвэр судалгааны үр дүн

“Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ” судалгааны асуулгын дагуу 153 ААН-ээс мэдээлэл цуглууллаа.

Зээлийн хэмжээ

Судалгаанд хамрагдсан 153 ААН-д нийт 584.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноос хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд 487.5 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 83.4%, газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлд 51.6 тэрбум төгрөг буюу 8.9%, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр 45.1 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 7.7%-г эзэлж байна. Зээлийн төрөл нь мэдэгдэж байгаа 146 байгууллагаас 4 байгууллага 3 төрлийн зээлтэй, 29 байгууллага 2 төрлийн зээлтэй байгаа юм. Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс давхардсан тоогоор 151 нь хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр, 20 нь газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр, 11 нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр зээлд хамрагджээ. Нэг байгууллагад ногдох зээлийн дундаж хэмжээ нь 3.8 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 2. ААН-үүдийн хамрагдсан зээлийн төрөл (n=146)

№	Зээлийн төрөл, 36-р тогтоолд заасан ангиллаар	ААН-ийн тоо
1	5.7.3 Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих	72
2	5.5.3 Хүнс, газар тариалангийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	44
3	5.2.3 Хүүхдэд зориулсан, импортыг орлох бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах	15
4	5.7.4 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг эргэлтийн хөрөнгөөр дэмжих	10
5	5.2.4 Орон нутагт сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хэрэглээнд зориулан хүнсний үйлдвэр байгуулах	8
6	5.2.1 Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	6
7	5.2.2 Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	5
8	3.8.1 Ногоо, бүх төрлийн будаа, элсэн чихрийг хадгалах агуулах зоорь байгуулахад дэмжлэг үзүүлэх зээл	5
9	4.3.2 Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээл	4
10	4.3.3 Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	2
11	3.5.2 Хүлэмжийн аж ахуй байгуулах зээл	2
12	3.4.1 Тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авахад эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгох	2
13	2.1.2.3 Тахианы аж ахуй эрхлэгчдэд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл	2
14	Анхан шатны үр үржүүлгийн төв, үтрэм байгуулах	2
15	5.6.3 Хүнсний ногооны хадгалалт, тээвэрлэлтийн зориулалтын хуванцар тэвшний үйлдвэр байгуулах	1
16	4.3.2 Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээл	1
17	5.6.4 Хүнсний ногоог хадгалах, тээвэрлэх, хуванцар тэвш, модны үрсэлгээ, тарьц суулгацын бортогоны үйлдвэр байгуулах	1

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид ихэнх нь байна. Эдгээр

бүтээгдэхүүнд олгосон зээл нь нийт олгосон зээлд ч өндөр хувь эзэлж байна. Тухайлбал, зээлийн 24.6% нь мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд олгогдсон байна (Хүснэгт 3). Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдэд нийт зээлийн 19.2% нь олгогджээ.

Хүснэгт 3. Зээлдэгчийн тоо ба зээлд эзлэх хувь, бүтээгдэхүүний төрлөөр (n=153)

Салбар	Тоо	Зээлийн хувь
Мах, махан бүтээгдэхүүн	39	24.6
Газар тариалан	22	7.3
Гурил, гурилан бүтээгдэхүүн	16	19.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн	12	12.8
Сав, баглаа боодол	11	4.5
Хүнс	11	10.9
Ундаа, ус	6	2.2
Жимс, жимсгэнэ	5	7.6
Бусад	31	10.9
Нийт	153	100.0

Эх сурвалж: Хүнс, хөдөө ах ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан ААН-ийг авсан зээлийн мөнгөн дүнгээр ангилбал 10 тэрбум төгрөгтэй тэнцүү буюу түүнээс дээш хэмжээний зээл авсан 12 ААН байгаа бөгөөд хамгийн их зээл авсан байгууллага нь 30 тэрбум төгрөгийн зээлтэй байна. 1–2 тэрбум төгрөгийг зээлийг хамгийн олон байгууллага буюу 48 байгууллага, 2-4 тэрбум төгрөгийн зээлийг 47 байгууллага авчээ. Харин хамгийн цөөн байгууллага буюу 9 байгууллага нь 6.0 тэрбум төгрөгтэй тэнцүү буюу түүнээс дээш 10.0 тэрбум төгрөгөөс бага төгрөгийн зээл байна.

Хүснэгт 4. Зээлийн хэмжээ ба давтамж (n=152)

Зээлийн хэмжээ, тэрбум төг.	ААН-ийн тоо
1 хүртэлх	25
1-2	48
2-4	47
4-6	11
6-10	9
10-аас дээш	12
Нийт	152

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Зээлийн зарцуулалт

Судалгаанд хамрагдсан 153 ААН-ээс 86 нь хөрөнгө оруулалтын зээл авсан ба давхардсан тоогоор 55 байгууллага нь техник тоног төхөөрөмж, 9 байгууллага нь тусгай тээврийн хэрэгсэл худалдан авахад зарцуулсан байна. Харин барилга барих, үйлдвэр өргөтгөх ажилд 38 байгууллага зээлийн санхүүжилтийг зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан 86 ААН-ийн хувьд нийт 489 ширхэг техник, тоног төхөөрөмж худалдаж авсан ба 185.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Мөн 53 ширхэг тусгай тээврийн хэрэгслийг 2.9 тэрбум төгрөгөөр худалдан авчээ.

Үүнтэй холбоотойгоор судалгаанд хамрагдсан ААН-үүдээс олгосон зээлийг шууд импортод зарцуулсан байдлыг тодруулав. Хүснэгт 5-д харуулснаар, хөрөнгө оруулалтын зээл авсан 39 ААН-ийн өгсөн хариултаас үзэхэд 25 ААН техник, тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслээ импортоор авчээ. Уг импортын дүн 94.4 тэрбум төгрөг бөгөөд энэ нь тэдний авсан зээлийн 42.9% болж байна. Харин эргэлтийн хөрөнгийн зээлд хамрагдсан 52 ААН-ийн 18 нь импортоор бараа, бүтээгдэхүүн авахад 46.4 тэрбум төгрөгийг зээлийн санхүүжилтээс зарцуулжээ. Энэ нь тэдний нийт авсан зээлийн дүнгийн 18.0% болж байна.

Хүснэгт 5. Зээлийн зарцуулалт ба импорт

Зээлийн зориулалт	Хариулт өгсөн ААН	Үүнээс импорт хийсэн ААН-ийн тоо	Импортын дүн, тэрбум төг.	Олгосон зээлээс импортод зарцуулсан хувь
Хөрөнгө оруулалтын зээл	39	25	94.4	42.9%
Эргэлтийн хөрөнгийн зээл	52	18	46.4	18.0%

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Техник, тоног төхөөрөмж худалдан авсан ААН-үүдийн хувьд гаалийн татварын хөнгөлөлтөд 16 байгууллага хамрагдаж, нийт 1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хөрөнгө оруулалтын зээлийн импорт ба гаалийн хөнгөлөлт

Зориулалт	Тоо ширхэг	Импорт (тэрбум төг.)	Гаалийн хөнгөлөлт эдэлсэн ААН	Гаалийн татварын хөнгөлөлт, (тэрбум төг.)	Импортоор авсан ААН, давхардсан тоогоор
Техник, тоног төхөөрөмж	560	187.1	16	1.3	21
Тусгай тээврийн хэрэгсэл	53	2.9	-	-	2
Нийт	613	190.0	-	-	21

Эх сурвалж: Хүнс, хөдөө ах ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Үйл ажиллагааны өөрчлөлт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс бүтээгдэхүүнийг нь жингээр хэмжих боломжтой үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 15.4 сая тонн байсан бол 2023 онд 17.5% хувь буурч 12.7 сая тонн болсон байна (Хүснэгт 7). Мөн ширхгээр хэмжигдэх бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9%-иар буурсан байна. Харин шингэн хүнсний хувьд 2022 онд 4516.4 сая литр байсан бол 2023 онд 10.9%-р өсөж 5007.8 сая литр болсон.

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйлдвэрлэл (n=119)

Хэмжих нэгж	2022 он	2023 он
Сая тн.	15.4	12.7
Сая ширхэг	46.7	46.3
Сая л	4516.4	5007.8

Эх сурвалж: Хүнс, хөдөө ах ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

ААН-үүдийн ажиллагсдын тоо, шинээр бий болгосон ажлын байрны тоо ч 2023 онд өмнөх жилтэй харьцуулахад өссөн байна. Жишээлбэл, зөвхөн эргэлтийн хөрөнгийн зээл авсан 58 байгууллагын ажилтны тоо 2022 онд 3020 байсан бол 2023 онд 3379 болж өсжээ (Хүснэгт 8). Зөвхөн хөрөнгө оруулалтын зээл авсан 43 байгууллага 2022 онд 190 ажлын байр шинээр үүсгэж байсан бол 2023 онд 442 ажлын байр шинээр бий болгосон байна. Эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зээлийг хамтад нь авсан 32 байгууллага 2023 оны нийт ажлын байрны 42.6%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд нийт ажилтны тоо болон шинээр бий болгосон ажлын байрны тоо ч өсөж байна.

Хүснэгт 8. Ажиллах хүчин болон шинээр нэмэгдсэн ажлын байрны тоо, зээлийн төрлөөр (n=133)

Зээл	Зээлдэгчийн тоо	2022 он ажиллаж байсан хүн	2023 он ажиллаж байгаа хүн	2022 он шинээр нэмэгдсэн ажлын байр	2023 он шинээр нэмэгдсэн ажлын байр
Эргэлтийн хөрөнгө	58	3020	3379	469	904
Хөрөнгө оруулалт	43	2842	3211	190	442
Эргэлтийн хөрөнгө + хөрөнгө оруулалт	32	4427	4897	369	606

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Ажиллах хүчин болон шинээр нэмэгдсэн ажлын байрны тоог зээлийн мөнгөн дүнгээр харьцуулъя. Хүснэгт 9-өөс харахад 2022 онд судалгаанд хамрагдсан 131 байгууллагад ажиллаж байсан 10284 хүний 4041 нь 10 тэрбум төгрөгөөс дээш зээл авсан 12 байгууллагад ажиллаж байжээ. Энэ нь 2022 оны ажиллагсдын 39.3%-ийг бүрдүүлж байгаа юм. Түүнчлэн 2023 оны ажиллагсдын 37.8%-ийг, шинээр нэмэгдсэн ажлын байрны 19.4%-ийг эдгээр 12 байгууллага бүрдүүлсэн байна.

Хүснэгт 9. Ажиллах хүчин болон шинээр нэмэгдсэн ажлын байрны тоо, зээлийн хэмжээгээр (n=131)

Зээлийн хэмжээ, тэрбум төг	Зээлдэгчийн тоо	2022 он ажиллаж байгаа хүн	2023 он ажиллаж байгаа хүн	2022 он шинээр нэмэгдсэн ажлын байр	2023 он шинээр нэмэгдсэн ажлын байр
1 хүртэл	13	312	388	61	76
1 – 2	44	1527	1587	261	435
2 – 4	47	3039	3600	334	832
4 – 6	8	631	720	73	103
6 – 10	7	733	851	82	125
10-аас дээш	12	4041	4334	317	379
Нийт	131	10284	11480	1128	1950


Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

2-4 тэрбум төгрөгийн зээл авсан 47 байгууллагад 2022 оны байдлаар 3039 хүн ажиллаж байсан нь нийт ажиллах хүчний 29.6% болжээ. Хамгийн өндөр зээлтэй 12 байгууллагаас 3.9 дахин олон байгууллага энэ бүлэгт байгаа ч ажиллаж байгаа хүний тоо 10012-оор

цөөн байна. Харин 2023 оны шинээр нэмэгдсэн ажлын байрны 42.7% буюу 832 шинэ ажлын байрыг эдгээр 47 байгууллага үүсгэжээ. Тэгвэл 1 тэрбум төгрөг хүртэлх зээлтэй 13 байгууллагад ажиллагсдын тоо болон шинээр нэмсэн ажлын байрны тоо харьцангуй бага байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагаа өргөжсөн тул 2023 онд борлуулалтын орлого нь мөн ихээр нэмэгджээ. Тухайлбал, 2022 онд хүнсний салбарын нийт борлуулалтын орлого 1665.2 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 1906.9 тэрбум төгрөг хүрч, 14.5% өссөн байна (Зураг 1). Харин газар тариалангийн ААН-үүдийн орлого 2022 онд 110.8 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 124.5 тэрбум төгрөг хүрч 12.4% өссөн байна. Мал аж ахуйн ААН-үүдийн борлуулалтын орлого 2023 онд өмнөх оноос 113.8% өсөж 12.3 тэрбум төгрөгөөс 26.3 тэрбум төгрөг хүржээ.

Зураг 1. Борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр (n=126)




Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Борлуулалтын орлогыг зээлийн төрлөөр авч үзвэл эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг хамтад нь авсан 32 байгууллага хамгийн өндөр борлуулалтын орлоготой байгаа бөгөөд 2023 оны нийт борлуулалтын орлогын 45.8%-ийг бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгийн зээл авсан 53 байгууллагын борлуулалтын орлого 2022 онд 669.1 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 748.6 тэрбум төгрөг болж өсжээ. Хөрөнгө оруулалтын зээл авсан 41 байгууллагын борлуулалтын орлого 335.3 тэрбум төгрөгөөс 360.5 тэрбум төгрөг болжээ.

Эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зээлийн хамтад нь авсан байгууллагуудын борлуулалтын орлого 2023 онд өмнөх оноос 20.5% буюу хамгийн ихээр өсжээ. Харин зөвхөн эргэлтийн хөрөнгийн зээл авсан байгууллагуудын борлуулалтын орлого 11.9% өссөн бол хөрөнгө оруулалтын зээл авсан байгууллагуудын борлуулалтын орлого 7.5% өсжээ.

Зураг 2. Борлуулалтын орлого, зээлийн төрлөөр, тэрбум төгрөг (n=126)



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Борлуулалтын орлогын дээрх өсөлт нь өмнө дурдсан үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоос гадна үнийн өсөлтөөс багагүй шалтгаалжээ. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 153 ААН-ээс 105 ААН үнийн мэдээллээ өгсөн бөгөөд эндээс тооцоход борлуулалтын үнэ 2023 онд өмнөх жилээс дунджаар 12.5% өссөн байна (Хүснэгт 10). Бүтээгдэхүүний төрлөөр дундаж үнийн өөрчлөлтийг харвал газар тариалангийн салбарт хамгийн их буюу 34.8%-аар өсжээ. Харин гурил, гурилан бүтээгдэхүүний салбарт 13 байгууллагын дундаж үнэ 14.8%-аар, мах махан бүтээгдэхүүний салбарт 35 байгууллагын дундаж үнэ 18.8%-аар тус тус өсжээ. Хамгийн бага өсөлттэй салбар нь сүү сүүн бүтээгдэхүүний салбар байгаа бөгөөд 12 байгууллагын үнийн мэдээлэлд үндэслэхэд үнэ 3.3% өсжээ.

Хүснэгт 10. Бүтээгдэхүүний үнийн 2022-2023 оны дундаж өөрчлөлт (n=105)

Салбар	Нэр төрөл	Үнийн дундаж өсөлт, %
Мах, махан бүтээгдэхүүн	35	18.8
Газар тариалан	13	34.8
Гурил, гурилан бүтээгдэхүүн	13	14.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн	12	3.3
Сав, баглаа боодол	11	4.4
Хүнс	11	5.2
Ундаа, ус	5	7.3
Жимс, жимсгэнэ	5	11.2
Нийт	105	12.5

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

ААН-үүдийн үйл ажиллагаа тэлсэн тул улсын төсөвт төвлөрүүлсэн татварын хэмжээ дагаад өссөн. Доорх хүснэгтээс харвал 2022 онд **газар тариалангийн салбар**ын 16 компани улсын төсөвт төвлөрүүлсэн нийт татварын хэмжээ 8.6 тэрбум төгрөг байсан ба үүнээс 634.3 саяыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-д төлсөн бол 340.1 саяыг хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-т суутган төвлөрүүлсэн байна. Газар тариалангийн 16 компанийн 2023 онд улсын төсөвт төвлөрүүлсэн нийт татварын хэмжээ 11.1 тэрбум төгрөг болж нэмэгдсэн ба үүнээс 636.6 саяыг ААНОАТ-д, 406.6 саяыг ХХОАТ-д тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын хэмжээ, сая төгрөгөөр (n=131)

Салбар	Нийт татвар		ААНОАТ		ХХОАТ	
	2022	2023	2022	2023	2022	2023
Мал ах ахуй	1819.7	2024.1	88.2	102.7	393.5	1000.4
Газар тариалан	8619.5	11140.6	634.3	636.6	340.1	406.6
Хүнс	95003.3	139010.4	24176.0	32314.3	15384.5	16084.8

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн яасны
үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Мал аж ахуйн салбарын 8 компани улсын төсөвт төвлөрүүлсэн нийт татварын хэмжээ 2022 онд 1.8 тэрбум төгрөг байсан ба үүнээс 88.2 саяыг ААНОАТ-д, 393.5 саяыг ХХОАТ-д тус тус төвлөрүүлсэн байна. 2023 онд нийт татварын хэмжээ 2.0 тэрбум төгрөг болж өссөнөөс 102.7 саяыг ААНОАТ-д, 393.5 саяыг ХХОАТ-д тус тус төвлөрүүлжээ.

Хүнсний салбарын 131 компани улсын төсөвт төвлөрүүлсэн нийт татварын хэмжээ 2022 онд 95.0 тэрбум төгрөг байсан ба үүнээс 24.2 тэрбумыг ААНОАТ-д, 15.4 тэрбумыг ХХОАТ-д тус тус төвлөрүүлсэн байна. 2023 онд нийт татварын хэмжээ 139.0 тэрбум төгрөг болж өссөнөөс 32.3 тэрбумыг ААНОАТ-д, 16.1 тэрбумыг ХХОАТ-д тус тус төвлөрүүлжээ.


Бусад

Судалгаанд хамрагдсан ААН-ээс 34 нь энэ хөтөлбөрийн зээлээс өөр зээлтэй байгаа гэж мэдээлсэн ба нийт зээлийн хэмжээ нь 203.3 тэрбум төгрөг буюу дунджаар 5.6 тэрбум төгрөгийн зээлтэй байна (Хүснэгт 12). Үүнээс эргэлтийн хөрөнгийн зээл хамгийн их хувийг буюу 64.8%-г эзэлж байна. Хоол хүнсний нөөц бэлтгэх, нөөцлөх зээлд 1 байгууллага ЗГ-ын хөнгөлөлттэй 8 тэрбумын зээл авчээ. Өөр зээлд хамрагдсан эдгээр 34 ААН-ээс 5 нь ЗГ-ын хөнгөлөлттэй зээлд хамрагджээ.

Хүснэгт 12. Өөр зээлтэй байгууллагын тоо, мөнгөн дүн (n=74)

Зээлийн зориулалт	Тоо	Мөнгөн дүн (тэрбум төг)	ЗГ-ын хөнгөлөлттэй
Эргэлтийн хөрөнгө	25	131.8	3
Хөрөнгө оруулалт	8	63.5	1
Нөөц бэлтгэх	1	8	1
Нийт	34	203.3	5

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Зураг 3.Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, тэрбум төгрөгөөр (n=128)

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагаа өргөжсөн тул эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө мөн нэмэгдсэн үзүүлэлттэй байгааг Зураг 3-аас харж болно. Тухайлбал, 2022 онд эргэлтийн хөрөнгө 1013.4 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 1330.4 тэрбум төгрөг хүрч 31.3% өссөн байна. Харин эргэлтийн бус хөрөнгийн хувьд 2022 онд 686.8 тэрбум төгрөг байснаас 2023 онд 894.4 тэрбум хүрч 30.2%-иар өсжээ.


З

ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

3.1. Хөтөлбөрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн суваг

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн нэг онцлог бол арилжааны банкнууд өөрсдөө зээлээ судалж, зээлийн шийдвэрээ төрийн ямар нэг байгууллагаас хамаарахгүйгээр гаргаж, өөрсдийн эх үүсвэрээр зээлээ олгож байгаа бөгөөд ЗГ зөвхөн хүүгийн зөрүүг төлж байгаа юм. Зураг 4-д хөтөлбөрийн зээлийн боломжит нөлөөг дүрслэв.

Зураг 4. Хөтөлбөрийн зээлийн боломжит нөлөө



Эх сурвалж: Судлаачдын төсөөлөл

Тэмдэглээ: *-сая төгрөгөөр

Арилжааны банкнуудын зээлийн шийдвэр ашгийн төлөө учраас хүнсний үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй гэсэн гурван салбарт олгосон зээлийг хэрвээ эдийн засгийн өөр салбаруудад олгосон бол гэдэгтэй холбоотой алдагдсан боломжийг тооцсон нь тодорхой юм. (Зураг 4, баруун доод хэсэгт ногоон өнгөөр ялгасан хэсэг) Мөн ЗГ-аас хүүгийн зөрүүг төлж байгаа нь тэдний хувьд зээлийн эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулна. Хөтөлбөрийн зээл эдгээр гурван салбарт хийж байгаа хөрөнгө оруулалт болох учраас ДНБ-ий зардал талын хөрөнгө оруулалтад нөлөөлнө. Үүнээс гадна үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-д хүнс, газар тариалан, мал аж ахуйн салбараар дамжин шууд нөлөөлнө. (Зураг 4, баруун хэсэгт хөх өнгөөр ялгасан хэсэг) Хөрөнгө оруулалтаар дамжин салбар тус бүрд шинэ ажлын байр бий болох тул хөдөлмөрийн зах зээл, тэр дундаа эдгээр салбарын ажил эрхлэлт, цалинд нөлөөлнө. (Зураг 1, зүүн доод хэсэгт хүрэн өнгөөр ялгасан хэсэг) Хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр хүнс, газар тариалан, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэгчид шинээр тоног төхөөрөмж худалдан авч, барилга байгууламж барьж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлж байгаа учраас төлөх татварын хэмжээ нэмэгдэнэ. Үүний зэрэгцээгээр эдгээр салбарт шинэ ажлын байр бий болж байгаа тул хүн амын орлогын албан татвар (ХАОАТ) өснө. Энд эдгээр салбарын үйл ажиллагаатай холбоотой бусад төрлийн татварын орлого ч нэмэгдэх боломжтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Арилжааны банкны эх үүсвэрээр хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эргэлтийн хөрөнгөөр дэмжих хүрээнд жилийн нийт 18 хувь (зээлдэгчээс 5 хувь, ЗГ-аас хариуцан төлөх 13 хувь)-ийн хүүтэй, 24 хүртэл сарын хугацаатай, мөн хөрөнгө оруулалтын, жилийн нийт 19 хувь (зээлдэгчээс 6 хувь, ЗГ-аас хариуцан төлөх 13 хувь)-ийн хүүтэй, 60 хүртэл сарын хугацаатай хөнгөлөлттэй зээлийг олгож байгаа учраас хүүгийн зардал төсвийн зардал талд нөлөө үзүүлнэ. (Зураг 4, зүүн дээд хэсэгт хар өнгөөр ялган харуулсан хэсэг) Эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зээлийн ЗГ-аас хариуцан төлж байгаа 13 хувийн хүү эдгээр салбарын зээл авсан үйлдвэрлэгчдийн зээлийн хүүгийн дарамтыг бууруулаад зогсохгүй, цаашилбал, дунд, урт хугацаанд үйлдвэрлэлийн зардал буурах үндсэн нөхцөлийг бүрдүүлэх учиртай. Иймд уг хөтөлбөрийн зээл цаашид нийлүүлэлтийн гаралтай инфляцад эдгээр салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дамжин тодорхой хэмжээнд нөлөөлнө. (Зураг 1, баруун дээд хэсэгт ногоон өнгөөр ялгасан хэсэг)

3.2. Хөтөлбөрийн зээлийн нийт эдийн засгийн нөлөөг тооцоход ашиглаж байгаа загварын тухай

Бид Чех Улсын Прага хотод төвтэй "OGR" судалгааны байгууллага (Унгарын нийслэл Будапешт хотод салбартай)-ын анхлан хөгжүүлж, одоо хөгжиж буй болон шинээр аж үйлдвэржиж буй улсуудын төв банк, төрийн судалгааны байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ хэрэглэдэг "GAP" загвар (хагас бүтцийн загварын төрөлд хамаарагддаг)-т үндэслэн хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлийн макро түвшинд үзүүлэх, цаашилбал, зарим нэг зан төлөвийн нөлөөг тооцно. Бид уг загварын 2016 онд Байгалийн нөөцийн засаглалын институт (БНЗИ (NRGI))-ийн Монгол Улсын онцлогт тохируулж, өргөтгөсөн хувилбарыг

ашигласан бөгөөд зарим жижиг өртгөтгөлийг хийсэн болно. Жишээлбэл, манай экспортын гол түүхий эд болох нүүрсийг загварт нэмж оруулсан. Түүнчлэн дунд хугацааны төсөөлөл хийхэд шаардлагатай зарим хувьсагчийг нэмсэн болно. Бидний ашиглах загвар *261 тэгшитгэлтэй, 261 хувьсагчтай*, ихэнх бүтцийн тэгшитгэл нь хувьсагчдын *"gap"* буюу *зөрүү, мөн тренд* буюу *урт хугацааны хандлагад* тус тус тулгуурлаж, бичигддэг. Загварын параметруудийн тухайд 277 параметрийг калибрац хийсэн бол 23 параметрийг үнэлсэн. Бид эдгээр 300 параметрийг ямар нэг өөрчлөлт хийхгүйгээр шууд авч, ашиглав.

Ерөнхийдөө бодлогын зардлын үнэлгээг хийхэд богино, дунд, урт хугацааны төсөөллийн загвар (цэвэр өгөгдөлд суурилсан вектор авторегрессив төрлийн загварууд, хагас бүтцийн загварууд (*"GAP"* загвар, CGEM буюу тооцоолох ерөнхий тэнцвэрийн загвар), бүтцийн буюу онолын загвар (динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загвар) гэх мэт)-уудад суурилдаг. Иймээс бид БНЗИ-ийн загварын өгөгдлийг санг (2005 оны I улирлаас 2016 оны 3-р улирал) 2023 оны 2-р улирлыг дуустал сунгаж, 2023-2028 оныг дуустал суурь төсөөлөл хийсэн (энэ загварыг суурь төсөөллийн загвар гэж нэрлэнэ!). Үүний дараа хөтөлбөрийн зээл болон бусад өгөгдөл, нэмэлт шаардлагатай тооцооллуудыг хийх замаар суурь төсөөллийн загвартаа тодорхой цочрол (шок)-уудыг өгч, макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн гол хувьсагчид, цаашилбал, үндсэн салбарууд, хөдөлмөрийн зах зээлийн хувьсагчдад тус тус ямар нөлөө үзүүлж байгааг тооцсон. Эцэст нь цочрол өгсөн үнэлгээний үр дүнг суурь төсөөллийн загварын үр дүнтэйгээ харьцуулж, дүгнэлт хийв. Зураг 4-д харуулсан хөтөлбөрийн зээлийн боломжит нөлөөг дүрсэлсэн диаграммд үндэслэн суурь төсөөллийн загварт ямар төрлийн цочролыг, хаана өгөх вэ гэдгээ шийдсэн.

Суурь төсөөллийн загварын үр дүнг Монголбанк (Инфляцийн тайлан, 2023 оны I, II, III, IV улирал), Дэлхийн банк (Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2023 оны 6-р сар, 2024 оны 1-р сар), Олон Улсын Валютын Сан (Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2023 оны 7-р сар, 2023 оны 10-р сар, 2024 оны 1-р сар)-гийн төсөөллийн үр дүнгүүдтэй харьцуулж, тодорхой урьдач нөхцөлүүдэд үндэслэсэн болно.

4 ХӨТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН НӨЛӨӨ

4.1. Төсөвт үзүүлэх шууд нөлөө

2023 онд олгосон хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээл нь төрлөөс хамаараад бага зэрэг ялгаатай нөхцөлтэй. Хөрөнгө оруулалтын зээл жилийн 6% хүүтэй, 5 жилийн хугацаатай, зээлдэгч эхний 12 сар зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Эргэлтийн хөрөнгийн зээл жилийн 5% хүүтэй, 3 жилийн хугацаатай, зээлдэгч эхний 6 сар зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Зээлийн хүүний төлбөрийг зээлдэгч хуваарийн дагуу сар бүр төлөх бол Засгийн газар хүүний дэмжлэг болох 13%-ийн төлбөрийг сар бүр арилжааны банкнуудад шилжүүлнэ.

ХХААХҮЯ-ны мэдээллээр энэ хөтөлбөрийн дагуу 2023 оны II улиралд 338.2 тэрбум, III улиралд 203.6 тэрбум, IV улиралд 291.0 тэрбум төгрөгийн зээл олгосон. Иймээс бид энэ тооцоонд Засгийн газар хүүний татаасыг 2023 оны 3-р улирлаас төлж эхэлсэн гэж үзэв. Улмаар эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүний татаас 2026 оны IV улирлыг дуустал, хөрөнгө оруулалтын зээлийн хүүний татаас 2028 оны IV улирлыг дуустал үргэлжилнэ гэж үзэв.

Дээрх нөхцөлүүдийг харгалзан 2023 онд олгосон 832.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт зориулж ирэх жилүүдэд улсын төсвөөс гарах хүүний дэмжлэгийн зардлыг дараах хүснэгтэд харуулав. Тухайн оны нэрлэсэн дүнгээр гарах нийт зардлын дүн 271.6 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 13. Хөтөлбөрийн улсын төсөвт үзүүлэх шууд ачаалал

	2023	2024	2025	2026	2027	2028
Хүүний дэмжлэг, тэрбум төгрөг	28.6	102.8	74.9	40.5	19.1	5.7

Энэхүү зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн байгууллагуудын ажлын нэмэлт ачаалал нь хариуцсан албан хаагчдын ажил үүргийн хуваарьт ямар нэг байдлаар тусаж байгууллагын төсөвт суусан, тооцсон зардлын дүн дээрх татаас дэмжлэгийн дүнтэй харьцуулахад маш бага гэж үзэв. Иймээс уг хөтөлбөрийн төсөвт үзүүлэх шууд нөлөө нь Хүснэгт 13-т харуулсан дүнгээр тодорхойлогдоно.

4.2. Эдийн засгийн шууд (статик) нөлөө

Зураг 4-д авч үзсэнээр уг хөтөлбөрийн зээлийн макро эдийн засгийн шууд нөлөө, тодруулбал, хэмжээний хувьд хамгийн том, анхдагч нөлөө эхлээд ДНБ-ийг, тэр дундаа хүнсний үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн салбарын ДНБ-д нөлөөлнө. Гэхдээ эдгээр салбарт олгосон зээл бүхлээрээ шууд ДНБ болохгүй, учир нь тодорхой хэсэг нь завсрын хэрэглээ, импортод зарцуулагдана. Үүнийг бид салбар хоорондын тэнцлийн өгөгдөл ашиглан, эдгээр гурван салбарын нийт үйлдвэрлэл буюу хэрэглээнээс хэдэн хувь нь дунджаар эцсийн бүтээгдэхүүн буюу ДНБ болох вэ гэдгийг тооцно. Энэ үр дүнг Хүснэгт 14-д харуулав. Энд бид 2012 оны 55 х 55 хэмжээтэй, 2015 оны 32 х 32 хэмжээтэй, мөн 2019 оны 32 х 32 хэмжээтэй салбар хоорондын тэнцлийг ашиглаж, эцсийн хэрэглээг нийт хэрэглээнд харьцуулж, хөтөлбөрийн зээлийн ДНБ лүү хөрвүүлэх коэффициентийг тооцлоо. Үүнийгээ салбар тус бүрийн олгосон зээлийн ДНБ-д хөрвөх хэмжээг тооцоход ашиглав.

Хүснэгт 14. Хөтөлбөрийн олгосон зээлийг ДНБ-д хөрвүүлэх коэффициент

Салбар	2012	2015	2019	Дундаж	Зээлийн хэмжээ*	ДНБ-д хөрвөх хэмжээ*
1 Газар тариалан	0.346	0.360	0.354	0.353	186,483	65,899
2 Мал аж ахуй, ан агнуур	0.576	0.632	0.498	0.568	54,196	30,802
3 Хүнсний үйлдвэрлэл	0.877	0.860	0.884	0.874	592,056	517,390

Тэмдэглээ: * - сая төгрөгөөр

Эх сурвалж: Судлаачдын хийсэн тооцоо

Хүснэгтээс харвал хүнсний үйлдвэрлэлийн 592.1 тэрбум төгрөгийн зээлийн 517.4 тэрбум төгрөг нь ДНБ-д хувь нэмэр оруулж байгаа бол газар тариалангийн салбарын 186.5 тэрбум төгрөгийн зээлийн зөвхөн 65.9 тэрбум төгрөг, мал аж ахуйн салбарын 54.2 тэрбум төгрөгийн зээлийн 30.8 тэрбум нь тус тус ДНБ болж байна. Нийт олгосон 832.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл нэрлэсэн ДНБ-ийг 2023 онд 614.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ гэсэн үг. Улирлын ДНБ-ий дефляторыг ашиглан эдгээр салбар тус бүрийн нэрлэсэн ДНБ рүү хөрвүүлсэн хэмжээг бодит ДНБ болгож, үр дүнг нэгтгэвэл уг зээлийн хөтөлбөр хэрэгжсэнээр 2023 онд 2022 онтой харьцуулснаар 1.14 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт эдийн засгийн өсөлтийг бий болгож байна. Үүнийг бид хөтөлбөрийн макро эдийн засагт үзүүлж байгаа шууд нөлөө гэж ойлгож болно. Хүснэгт 15-т салбар тус бүрийн бодит ДНБ-ий тооцооллын үр дүнг улирлаар, мөн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээлээр ангилан харуулав. Суурь төсөөллийн загварын дунд хугацааны төсөөлөл 2023 оны III улирлаас эхэлж байгаа учраас загварт

хөтөлбөрийн зээлийн цочролыг өгөхийн тулд 2023 оны II улирлын зээлийг III улирал руу нэгтгэсэн болно. Нийт олгосон хөнгөлөлттэй зээл нэрлэсэн ДНБ-ийг 2023 онд 614.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх бол 2010 оны үнээр тооцсон бодит ДНБ-ийг 219.3 тэрбум төгрөгөөр (1.14 хувийн өсөлт) нэмэгдүүлнэ. Бодит байдалд ДНБ-д үзүүлж байгаа хөтөлбөрийн зээлийн энэ нөлөөг бууруулах олон хязгаарлалт бий. Гэхдээ бид өгөгдлийн дутмаг байдлаас шалтгаалж, хязгаарлалт бүрийн нөлөөг нарийвчлан тооцож, оруулах боломжгүй. Хөтөлбөрийн зээлийн шууд бус, үйл хөдлөлийн нөлөөг тооцохдоо зарим нэг хязгаарлалтыг тооцож, оруулах болно.

Хүснэгт 15. Хөтөлбөрийн олгосон зээлийн бодит ДНБ-д хөрвөх хэмжээний дэлгэрэнгүй тооцоо

Нэрлэсэн ДНБ-д хөрвөх хэмжээ				
	Хүнсний салбарын зээл		Хөдөө аж ахуйн салбарын зээл	
	Хөрөнгө оруулалт	Эргэлтийн хөрөнгө	Хөрөнгө оруулалт	Эргэлтийн хөрөнгө
2023-III	179,133.8	128,313.8	22,822.4	54,103.7
2023-IV	111,028.1	98,914.4	13,031.3	6,742.7
Бодит ДНБ-д хөрвөх хэмжээ				
	Хүнсний салбарын зээл		Хөдөө аж ахуйн салбарын зээл	
	Хөрөнгө оруулалт	Эргэлтийн хөрөнгө	Хөрөнгө оруулалт	Эргэлтийн хөрөнгө
2023-III	58,930.5	42,212.0	10,699.5	25,364.7
2023-IV	40,221.4	35,833.0	3,968.9	2,053.6

Тэмдэглээ: *-сая төгрөгөөр

Эх сурвалж: Судлаачдын хийсэн тооцоо

4.3. Эдийн засгийн нийт нөлөө

Хөрөнгө оруулалтын зээл (нийт зээлийн 50.6 хувь) тухайн салбарын тренд буюу урт хугацааны хандлагад нөлөөлөх бол эргэлтийн хөрөнгийн зээл (нийт зээлийн 49.4 хувь) ДНБ-ий зөрүү буюу богино хугацааны өөрчлөлтөд нөлөөлнө. Улирлын ДНБ-ий дефляторыг ашиглан эдгээр салбар тус бүрийн нэрлэсэн ДНБ рүү хөрвүүлсэн хэмжээг бодит ДНБ болгосон үр дүнг ашиглан (Хүснэгт 3) суурь төсөөллийн загварын салбарын ДНБ-ийн зөрүү, мөн трендийг өөрчлөх замаар цочролоо өгч, хөтөлбөрийн зээлийн нөлөөг тооцохдоо дараах урьдач нөхцөлийг тавив.

- ✓ Хөрөнгө оруулалтын зээл тоног төхөөрөмж худалдаж авах, барилга байгууламж барихад зарцуулагдаж учраас үйлдвэрлэлд бодитоор нөлөөгөө өгч эхлэхэд нэлээд хугацаа шаардагдана. Иймд хөрөнгө оруулалтын зээлийн 50 хувийн үр дүнг 2024 оноос эхэлж гарна гэж үзлээ. Энэ урьдач нөхцөлийг капиталд хийж байгаа хөрөнгө оруулалтын онолын судалгааны үндэслэл, зээл авсан ААН-үүдийн төлөөлөлтэй уулзсан үр дүн, мөн ХХААХҮЯ болон ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаанд хамрагдсан 150 орчим ААН-ийн мэдээлэлд үндэслэв.
- ✓ Эргэлтийн хөрөнгийн зээлийн 25 хувийг 2024 оноос үр дүнгээ өгнө гэж үзэв. 2023 оны эцсээр авсан зээл тухайн ондоо шууд нөлөөгөө өгөх магадлал тун бага юм.

Дээрх хоёр урьдач нөхцөлийг ашиглавал өмнө тооцсон хөтөлбөрийн зээлийн 2023 оны ДНБ-д үзүүлэх статик нөлөө өөрчлөгдөнө. Өмнө хийсэн тооцоогоор (Хүснэгт 14) хүнсний салбарын хөрөнгө оруулалтын зээлийн 2023 оны бодит ДНБ-д үзүүлэх нөлөө 99,151.8 сая төгрөг байсан бол үүний 50 хувь нь хойшилж, 2024 онд нөлөөгөө үзүүлнэ гэвэл 49,575.9 сая төгрөг болно. Үүнтэй адил ХАА-ын салбарын хөрөнгө оруулалтын зээлийн 2023 оны бодит ДНБ-д үзүүлэх нөлөө 14,668.4 сая төгрөг байсан бол 7,334.2 сая төгрөг болно. Мөн хүнсний салбарын эргэлтийн хөрөнгийн зээлийн 2023 оны бодит ДНБ-д үзүүлэх нөлөө 78,045.0 сая төгрөг байсан бол үүний 25 хувь хойшилж, 2024 онд нөлөөгөө үзүүлнэ гэвэл 58,533.7 сая төгрөг болох бол ХАА-ын салбарын эргэлтийн хөрөнгийн 2023 оны бодит ДНБ-д үзүүлэх нөлөө 27,418.3 сая төгрөг байсан бол 20,563.7 сая төгрөг болно. Эцэст нь дээрх хоёр урьдач нөхцөлийг харгалзсан хөтөлбөрийн зээлийн 2023 оны бодит ДНБ-д үзүүлэх нийт нөлөөг тооцвол 136,007.5 сая төгрөг болох бөгөөд үүнийг 2022 онтой харьцуулбал 0.7 хувийн өсөлтийг нэмж, бий болгоно гэсэн үг юм. Энэ тооцоонд үндэслэсэн хөтөлбөрийн нөлөөтэй загвар ба суурь төсөөллийн загварын хоорондын зөрүүг гол хувьсагчдаар Хүснэгт 16-д харууллаа. (Дэлгэрэнгүй үр дүнг "model_result_prgm_s3" нэртэй дагалдах эксел файлаас харна уу)

Хүснэгт 16. Хөтөлбөрийн олгосон зээлийн нийт нөлөө

Макро эдийн засгийн хувьсагчид						
#	Хувьсагч (2010 оны үнээр, сая ₮)	2023	2024	2025	2026	2027
1	ДНБ	135,510.5	321,511.1	375,482.0	403,975.3	426,585.8
2	Хувийн хэрэглээ	52,127.2	156,933.4	196,143.9	218,524.5	234,800.4
3	Засгийн газрын хэрэглээ	17,806.8	51,454.8	64,435.0	73,548.6	80,327.1
4	Нийт капиталын хуримтлал	34,654.6	99,271.1	130,118.7	144,318.5	153,788.7
5	Экспорт	81,379.3	223,921.7	286,613.2	314,926.6	330,080.0
6	Импорт	- 26,282.3	104,568.7	220,264.8	280,820.8	311,498.3
7	ДНБ: ХАА	38,780.0	120,200.3	142,078.0	151,872.0	156,857.6
8	ДНБ: Уул уурхай	129.2	82.0	4,811.2	7,328.5	8,602.2
9	ДНБ: Бусад	97,919.1	211,465.7	237,624.3	251,785.0	265,225.8

ДНБ-ий дефляторууд, нэгжээр						
#	Дефлятор	2023	2024	2025	2026	2027
1	ДНБ	- 0.001	- 0.005	- 0.006	- 0.010	- 0.013
2	Хувийн хэрэглээ	- 0.001	- 0.006	- 0.010	- 0.013	- 0.015
3	Засгийн газрын хэрэглээ	- 0.001	- 0.005	- 0.009	- 0.012	- 0.014
4	Нийт капиталын хуримтлал	- 0.001	- 0.005	- 0.008	- 0.011	- 0.013
5	Экспорт	0.000	0.002	0.004	0.003	0.002
6	Импорт	0.000	0.000	- 0.001	- 0.002	- 0.003
7	ДНБ: ХАА	- 0.002	- 0.007	- 0.010	- 0.012	- 0.015
8	ДНБ: Уул уурхай	0.000	0.009	0.015	0.013	0.011
9	ДНБ: Бусад	-0.001	-0.005	-0.008	-0.011	-0.015
Макро эдийн засгийн хувьсагчид						
#	Хувьсагч (оны үнээр, сая ₮)	2023	2024	2025	2026	2027
1	ДНБ	416,821.3	1,010,571.5	1,305,391.9	1,453,162.2	1,577,388.2
2	Хувийн хэрэглээ	112,396.9	341,593.0	428,639.1	486,115.7	533,319.3
3	Засгийн газрын хэрэглээ	35,646.3	102,850.9	130,032.3	152,576.7	171,615.8
4	Нийт капиталын хуримтлал	66,076.8	189,523.0	250,961.8	282,826.6	306,545.5
5	Экспорт	145,984.0	472,886.0	733,414.7	818,667.0	863,288.0
6	Импорт	- 38,426.6	127,505.5	267,905.4	331,919.6	357,262.8
7	ДНБ: ХАА	93,668.4	304,766.8	385,755.5	434,049.2	469,839.8
8	ДНБ: Уул уурхай	634.2	44,897.8	119,546.0	134,121.6	134,175.3
9	ДНБ: Бусад	279,726.3	587,981.7	713,773.8	779,503.1	839,853.8
Санхүүгийн зах зээлийн хувьсагчид						
#	Хувьсагч	2023	2024	2025	2026	2027
1	Бодлогын хүү, %	0.001	- 0.030	-0.076	- 0.077	- 0.066
2	ХҮИ, %	- 0.062	- 0.179	- 0.120	- 0.083	- 0.063
3	Эрсдэлийн шагнал, %	0.064	0.060	0.002	- 0.006	- 0.005
Хөдөлмөрийн зах зээлийн хувьсагчид						
#	Хувьсагч	2023	2024	2025	2026	2027
1	Хувийн секторын ажил эрхлэлт	718.0	5,442.3	7,469.4	8,749.4	9,657.4
2	Ажил эрхлэлт: ХАА	- 1,588.3	384.5	684.9	705.6	707.1
3	Ажил эрхлэлт: Уул уурхай	21.5	16.0	23.1	26.0	26.6
4	Нэрлэсэн цалингийн өсөлт, %	0.1	0.2	0.0	0.0	0.0
5	Нэрлэсэн цалингийн өсөлт: ХАА, %	0.2	0.4	- 0.1	- 0.1	- 0.1

Эх сурвалж: Судлаачдын хийсэн тооцоо

Хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр 2023, 2024, 2025, 2026, 2027 онд 2010 оны үнээр зэрэгцүүлэн тооцсон бодит ДНБ-ийг суурь төсөөллийн загварын үр дүнтэй харьцуулснаар харгалзан 135.5 тэрбум төгрөг, 321.5 тэрбум төгрөг, 375.5 тэрбум төгрөг, 404 тэрбум төгрөг, 426.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна. Үүний зэрэгцээгээр Хүснэгт 16-аас 2010 оны үнээр зэрэгцүүлсэн бодит ДНБ-ий зардлын бүрэлдэхүүний 2023-2027 оны төсөөлөлд хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгаа тодорхой харах боломжтой. Үүнийг ерөнхийд нь дүгнэвэл тус хөтөлбөр ДНБ-ий бүрэлдэхүүн тус бүрийг өсгөх нөлөөг дунд хугацаанд үзүүлэхээр харагдаж байна. Түүнчлэн хөтөлбөрийн нөлөөгөөр ХҮИ-ийн жилийн өсөлт буюу инфляцын түвшин 2023 онд 0.1 хувиар, 2024 онд 0.2 хувиар, 2025, 2026, 2027 онуудад тус тус 0.1 хувиар тус тус буурах ажээ. Хөдөө аж ахуйн салбарын ажил эрхлэлт 2023 оныг эс тооцвол дунд хугацаанд хөтөлбөрийн нөлөөгөөр тасралтгүй өсөх хандлагатай байгаа бол нэрлэсэн цалингийн өсөлтөд мөн эерэг нөлөөтэй байна. Хүнсний салбарын ажил эрхлэлт, нэрлэсэн цалингийн өсөлт дэх нөлөөг шууд тооцох боломжгүй, үүний шалтгаан бидний ашиглаж байгаа загварт ДНБ-ийг зөвхөн ХАА, уул уурхай, бусад гэсэн гурван хэсэгт хувааж авч үзэж байгаад оршино.

Суурь төсөөллийн загвар ба хөтөлбөрийн цочролтой загварын хоорондох бодит ДНБ, түүний салбарын задаргаа, мөн бодит ДНБ-ий зардлын бүрэлдэхүүний тус бүрийн өсөлтийн зөрүүг тооцож, Хүснэгт 17-д харуулав. Эндээс дүгнэвэл хөтөлбөрийн зээлийн нөлөө бодит ДНБ, ХАА-н бодит ДНБ, бусад салбарын бодит ДНБ, мөн бодит ДНБ-ий зардлын бүрэлдэхүүн хэсэгт тус тус 2023, 2024 онд илүү хүчтэй нөлөөлөөд цаашид нөлөө нь саармагжих хандлагатай байна. Тухайлбал, суурь төсөөллийн загвар ба хөтөлбөрийн цочролтой загварын хоорондох бодит ДНБ-ий өсөлтийн зөрүү 2023 онд 0.7 хувь, 2024 онд 0.9 хувь байх бөгөөд цаашид энэ зөрүү тасралтгүй буурсаар 2027, 2028 онд тэгтэй тэнцүү болно.

Хүснэгт 17. Хөтөлбөрийн олгосон зээлийн нийт нөлөө: Бодит ДНБ, түүний салбар ба зардлын бүрэлдэхүүний өсөлтийн зөрүү

#	Хувьсагч (2010 оны үнээр)	2023	2024	2025	2026	2027
1	ДНБ	0.7	0.9	0.2	0.1	0.0
2	Хувийн хэрэглээ	0.4	0.8	0.2	0.1	0.0
3	Засгийн газрын хэрэглээ	0.5	0.8	0.2	0.1	0.1
4	Нийт капиталын хуримтлал	0.4	0.8	0.3	0.1	0.0
5	Экспорт	0.4	0.4	0.1	0.0	0.0
6	Импорт	- 0.1	0.4	0.3	0.1	0.0
7	ДНБ: ХАА	1.4	3.0	0.7	0.3	0.1
8	ДНБ: Уул уурхай	0.0	0.0	0.1	0.0	0.0
9	ДНБ: Бусад	0.7	0.8	0.1	0.0	0.0

Эх сурвалж: Судлаачдын хийсэн тооцоо

5 ДҮГНЭЛТ

УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, уг тогтоолыг дэмжих зорилго бүхий 2023 оны УИХ-ын түр хорооны 02 дугаар тогтоол, мөн Засгийн газрын 2023 оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолоор арилжааны банкны эх үүсвэрээр хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгөөр дэмжихэд зориулж 2023 оны II-IV улиралд нийт 832.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Энэхүү хөнгөлөлттэй зээлийн нөлөөг хагас бүтцийн “GAP” загварыг ашиглан тооцлоо. Энэ тооцоог хийхийн тулд эхлээд “GAP” загвар (суурь төсөөллийн загвар)-аар 2023-2025 оны хоорондох дунд хугацааны төсөөлөл хийв. Дунд хугацааны төсөөлөлд Монголбанк (Инфляцын тайлан, 2023 оны I, II, III, IV улирал), Дэлхийн банк (Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2023 оны 6-р сар, 2024 оны 1-р сар), Олон Улсын Валютын Сан (Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2023 оны 7-р сар, 2023 оны 10-р сар, 2024 оны 1-р сар)-гийн зарим макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хувьсагчийн өгөгдлийг ашиглаж, эдгээр төсөөллийн үр дүнтэй харьцуулж, тодорхой урьдач нөхцөлүүдэд үндэслэн гүйцэтгэсэн болно.

Суурь төсөөллийн загварт хөтөлбөрийн зээлийн цочролоо өгөхийн тулд эхлээд хүнс, газар тариалан, мал аж ахуй гэсэн гурван салбарт олгосон зээл буюу хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээлийн хэдэн хувь нь дунджаар нэмэгдэл өртөг буюу ДНБ болох вэ гэдгийг 2012, 2015, 2019 оны салбар хоорондын тэнцэлд үндэслэж, тооцлоо. Бодит байдалд хөтөлбөрийн зээлээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт макро эдийн засагт нөлөөлж эхлэхэд тодорхой хугацаа шаардагддаг (тоног төхөөрөмж худалдаж авах, суурилуулах, барилга байгууламж барих) гэсэн онолын үндэслэлтэй нийцүүлэн, хөрөнгө оруулалтын зээлийн 50 хувь, эргэлтийн хөрөнгийн зээлийн 25 хувийг тус тус 2024 он руу шилжүүлж, хөтөлбөрийн зээлийн 2023 оны бодит ДНБ-ийг өсгөх хэмжээг 136 тэрбум төгрөг байхаар тооцож, суурь загвартаа цочролоо хүнс, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-ий зөрүү, эсвэл урт хугацааны хандлага буюу трендэд өгөх замаар хөтөлбөрийн зээлийн нөлөөний тооцоог хийв.

Эндээс нэгтгэн дүгнэвэл, 2023 онд олгогдсон 832.7 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл 2023 онд 0.7 хувь, 2024 онд 0.9 хувьтай тэнцэх нэмэлт эдийн засгийн өсөлт бий болгоод цаашид нөлөө нь саармагжиж байна. Үүний зэрэгцээгээр дунд хугацаанд бодит ДНБ-ий зардлын бүрэлдэхүүн болох хувийн хэрэглээ, засгийн газрын зардал, нийт капиталын хуримтлал, экспорт, импортыг өсгөх нөлөөтэй байх бөгөөд 2024 оноос эдгээр бүрэлдэхүүнд үзүүлэх хөтөлбөрийн зээлийн нөлөө буурсаар 2027, 2028 онд тэг болж байна. Хэрэглээний үнийн индексийн жилийн өсөлт буюу инфляцын түвшин дунд хугацаанд хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр 0.1-0.2 нэгж хувиар буурахаар байна. Мөн

дунд хугацаанд хөдөө аж ахуйн салбарын ажил эрхлэлт, 2023, 2024 онуудын нэрлэсэн цалингийн түвшинд тус тус эерэг нөлөөлөхөөр байна.

Эцэст нь хэрвээ хөтөлбөрийн зээлийн шууд, шууд бус, үйл хөдлөлийн нөлөөг тооцоход ашигласан загвар өөрчлөгдөх, мөн 'GAP' загвараар дунд хугацааны төсөөлөл хийхэд тавьсан урьдач нөхцөлүүд, цочрол буюу шок өгөхөд хийсэн нэмэлт тооцоонд авч үзсэн урьдач нөхцөлүүд тус тус өөрчлөгдвөл хөтөлбөрийн зээлийн нөлөөний үр дүн мөн өөрчлөгдөнө гэдгийг анхаарах нь зүйтэй.

